



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/35

Арвайхээр

Нутгийн захиргааны байгууллагын 2019 оны
үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-
шинжилгээ, үнэлгээний дүнгийн тухай

Аймгийн Засаг даргын 2017 оны а/552 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 10 дугаар зүйлийн 10.13.а, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нутгийн захиргааны байгууллагын 2019 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр тэргүүлсэн Бат-Өлзий, Арвайхээр, Гучин-Ус, Богд, Бүрд сумдыг тус бүр 2.000.000 (хоёр сая) төгрөг, аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Орон нутгийн өмчийн газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтсийг тус бүр 1.000.000 (нэг сая) төгрөгөөр шагнасугай.

2. Шагналын зардалд шаардагдах нийт 15.000.000 (арван таван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

3. Үйл ажиллагааны үр дүнгээр тэргүүлсэн аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Орон нутгийн өмчийн газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтсийн дарга нарт, Бат-Өлзий, Арвайхээр, Гучин-Ус, Богд, Бүрд сумдын Засаг дарга, түүний Тамгын газрын дарга нарт тус бүр нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг тухайн байгууллагын төсвөөс олгохыг нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100073